

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

ҮНДЭСНИЙ БОЛОН БҮХ НИЙТИЙН ЭРХ АШИГ

Д. Базаргарьд

Энэ асуудал бүх нийтийн энх тайван, олон улсын аюулгүй байдлыг хамгаалан бэхжүүлэх явдал дэлхийн дэвшилт олон нийтийн анхаарлын төвд оршиж байгаа одоо үед онцгой хурцаар тавигдаж байна.

Нийгмийн эсрэг тэсрэг хоёр системийн тэмцэл эрс хурцдаж, зэвсэгт сөргөлдөөний заагт тулж очоод байгаа нөхцөлд дайн ба энхийн асуудалд яаж хандах нь улам бүр интернационалч шинж чанартай болж байна. Өөрөөр хэлбэл одоо үед дайны аюул нийт хүн төрөлхтөн цаашид амьдрах эсэх асуудлыг шууд хөндөж байгаа учраас тэр аюулыг сэрэмжлэн зайлуулж хүн төрөлхтөн түүний зол жаргал, соёл иргэншлийг хамгаалах зорилт нь аль нэг улс орны хүрээнээс хальж бүх нийтийн амин чухал эрх ашгийн үйлс болж байна. Империализм, юуны өмнө бүх улс түмний заналт дайсан америкийн империализмийн харгис чанар, түрэмгий авир эрс гарч байгаагийн уршгаар дэлхий дахины байдал маш ноцтойгоор хурцадлаа. Ийм явдал дэлхийн хоёрдугаар дайнаас хойших 39 жилд тохиолдсонгүй. Бүс нутгийн чанартай байлдаан тулалдаан цөөнгүй болж байсан боловч өнөөдрийнх шиг ингэж бүх хүн төрөлхтний хувь заяаны асуудлыг хөндөхөд хүрээгүй юм.

Капиталистууд сөнөж мөхөх тавилантай нийгмийн системээ аврах, дэлхийн хувьсгалт үйл явцыг зэр зэвсгийн хүчээр нухчин дарахын тулд хамгийн балмад аргад шилжиж, улс төрийн тайзанд хэт даварсан хэрцгий этгээдийг дэвшүүлж тавьдгийг түүх сайн мэднэ. Чухамхүү тийм замаар Адольф Гитлер засгийн эрхэнд орж байсан удаатай. Одоо тэр ролийг Голливудийн кино жүжигчин агсан Рейган, түүний шадар бараа бологсод, Вашингтоны засаг захиргааныхан гүйцэтгэх гэж махран тэмүүлж байна.

Гэвч иймэрхүү этгээд аль нэг орны засгийн эрхэнд орох удаа тохиолдовч эцсийн дүнд тэднийг шударга ёс шүүрдэн арилгаж, ард түмэн, улс орон хэвээр үлддэгийг ч бас түүх гэрчлэх билээ.

Энэ удаа дэлхий дахины байдал эрс хурцадсаны хамаг аюул нь империалистүүдийн зэвсгээр хөөцөлдөх хөнөөлт практикийн цар хүрээ маш өргөжиж, хүнийг үй олноор хүйс тэмтрэн хядах зэр зэвсгийн нөөц хэзээ ч байгаагүй асар их хэмжээнд хүрсэнд оршино. Тэгэхдээ энэ бүх нь урьд урьдын дайнд хэрэглэж байсан жирийн зэвсэг биш, чухамхүү халуун цөмийн буюу орчин үеийн шинжлэх ухаан—техникийн хувьсгалын хамгийн сүүлчийн ололтыг ашиглан хийсэн зэвсэг юм.

Нэг үгээр хэлэхэд, өнөөдөр халуун цөмийн дайн дэгдвэл хүн төрөлхтөн, түүний олон мянган жилийн соёл иргэншлийг үе удмаар нь таслан сөнөөх тийм аюул бүрдээд байна. Манай дэлхий дээр хуримтлагдаад байгаа тэслэх дэлбэлэх зэвсэг хэрэгслийг барагцаалан тооцвол бүх тивийн оршин суугч нэг бүрт түүний дотор манцуйтай хүүх-

дэд хүртэл 15 орчим тонн тэслэх бодис ноогдож байна. Ус төрөгчийн ганц бөмбөг гэхэд л 1945 онд Японы Хиросима хотод америкийнхний хаясан атомын бөмбөгнөөс 50 дахин илүү чадалтай бөгөөд нейтроны арваад бөмбөг нь Парис хотын хүн амыг бүрэн устгах чадалтай болоод байна. Зөвхөн цэргийн объект руу чиглэсэн стратегийн хэрэгслийн ганц удаагийн хязгаарлагдмал цөмийн цохилт нь агшин зуур 10 сая хүнийг сөнөөж, уудам их нутгийг хүн амьтан амьдрах нөхцөлгүй болгож, дараа дараачийн олон үеийнхэнд хэмжээлшгүй гай зовлон учруулах юм.

Ийм ч учраас эрүүл соргог ухаантан бүхэн цөмийн дайны хор аюулыг ухамсарлан, түүний эсрэг тэмцлийг юу юунаас чухалд үзэж байна.

Ерөөсөө дайн байлдаан хэзээ боловч үхэл хагацал, үгүйрэл, хоосролоос өөр юуг ч өгдөггүйг ялангуяа жирийн хөлөлмөрч хүн ард сайн мэддэг болохоор амгалан тайван аж төрөх боломжийг энэ насны дээдийн жаргал гэж үзэж дайны аюулын эсрэг тууштай тэмцээр ирсэн түүхтэй.

Дэлхийн социализмын байр суурь улам бүр батжин, энхийг эрхэмлэх бодлогыг хэлбэрэлтгүй явуулсны ачаар сүүлийн 40-өөд жил хүн төрөлхтөн бүхэлдээ энх түвшин нөхцөлд амьдарлаа. Гэсэн ч империалист түрэмгий хүчний балгаар янз бүрийн зэвсэгт мөргөлдөөн, цус урсгасан самуун дажин их бага хэмжээгээр үүсч үй түмэн хүн ардыг үхэл зовлонд учруулах, тахир татуу болгох, хот, суурин, эд агуурс, тариалан, бэлчээрийг бүрэлгэн сүйтгэх хөнөөлт явдал тасарсангүй. 1945 оноос 1972 оныг дуустал дэлхий дээр нийтдээ 113 удаа ноцтой будлиан үүсч, 25 сая орчим хүний амь нас үрэгджээ. Тийм аюулт сүйрэл Ойрхи Дорнод, Төв Америк зэрэг газар одоо ч үргэлжилж байна.

Энэ бүхнийг санаачлагчид нь олон улсын империализм, зэр зэвсэг үйлдвэрлэн хүний амиар панз хийж, олз ашгийн хойноос улайран хөөцөлдөгч цэрэг-аж үйлдвэрийн хамсал, тэдний дуулгавартай зарц-империалист гүрний эрх баригч түрэмгий бүлгийнхэн мөн гэдгийг хөрөнгөтөн ертөнцийн төр, олон нийтийн нэрт зүтгэлтнүүд ч хүлээн зөвшөөрч байна. Монопольтны ашиг сонирхол нь империалист гүрний эрх баригч түрэмгий бүлгийнхний их гүрний жанжлах санаархал, дэлхийн социализм, хувьсгалт бүх хүчнийг эсэргүүцэн дарах эрмэлзэлтэй хослон нийлж байгаа нь байдлыг улам ч аюултай болгож байна. Чухамхүү энэ байдал империалист харгис хүчнийг улам бүр зоригжуулж, Зөвлөлт Холбоот Улсыг болон нийт социалист хамтын нөхөрлөлийг эсэргүүцэх явдлыг тэргүүн зэрэгт тавих, зэр зэвсгийн хувьд давуу байдал олж авах, цаашлаад ЗХУ, социалист бусад орны эсрэг цөмийн эхний цохилт хийх зорилгоор Европт 108 «першинг—2», 454 далавчит пуужин байрлуулах гэж махран оролдоход хүргэлээ. Тэр зорилгодоо хүрэхийн тулд харгис хүч янз бүрийн жигшүүртэй заль мэх зохиож бузар өдөөн хатгалга хийсээр байна.

Америкийн империалистүүд АНУ-аас хэдэн арван мянган километрийн алсад орших нутаг районыг өөрсдийн «амин чухал эрх ашгийн бүс» гэж зарлаад цэрэг зэвсгээ газар сайгүй нэвтрүүлж байна.

Өнөөдөр үнэн чанартаа социалист хамтын нөхөрлөлийн болон социалист чиглэл баримталж буй орнуудыг эс тооцвол америкийн цэрэг, зэвсэг нэвтрээгүй стратегийн чухал район дэлхий дээр бараг байхгүй болжээ. Одоо дэлхийн 30 гаруй улсын нутагт АНУ-ын 1500 гаруй цэргийн бааз болон бусад объект хагас сая гаруй цэргийн албан хаагчдын хамт байрлаж байна. Зөвхөн өрнөд Герман гэхэд л америкийн

200 орчим цэргийн том объект ажиллаж байгаа бөгөөд энэ орныг Вашингтоны засаг захиргаа Варшавын гэрээний орнуудын эсрэг дайн дэгдээх эцсийн гишгүүр гэж үзэж, түүнийг одоо бүр шинэ маягийн улам чадалтай бөгөөд олон зуун пуужингаар зэвсэглэх гэж зүтгэсээр байна.

Америкийн гадаад дахь зэвсэгт хүчний 300 гаруй цэргийн объект олон арван цэргийн баазаас бүрдсэн хоёр дахь том бөөгнөрөл нь Ази болон Номхон далайн сав нутагт байрлаж байна. Үүний хамтад АНУ-ын өчнөөн төчнөөн авианосец Номхон, Энэтхэгийн болон Атлантын далай, Газрын дундад тэнгист хөвж явааг хэлэх хэрэгтэй юм. Зөвхөн Энэтхэгийн далайд америкийн 140 мянган цэрэг бүхий 30 бааз байрлаж, энд цэргийн 40 хөлөг онгоц далайг хэрж явна.

Гэтэл үүнд империалист дайнчдын сэтгэл огтхон ч ханахгүй, зэвсгээр хөөцөлдөх хэнээрхлээ улам дэвэргэсээр байна. АНУ-ын засаг захиргаа 1984 оны цэргийн зардлыг асар их хэмжээгээр нэмэгдүүлж нийт 280,5 миллиард доллараар баталжээ. Пентагон хамгийн орчин үеийн зэвсэг худалдан авах, АНУ-ын зэвсэгт хүчний байлдааны бэлэн байдлыг улам бүр дээшлүүлэхэд 190 миллиард доллар, алсын нислэгийн «В—1» бөмбөгдөгч шинэ онгоц үйлдвэрлэхэд 6 миллиард гаруй доллар, стратегийн «МХ» маягийн шинэ пуужин хийхэд 2,2 миллиард доллар тус тус зарцуулахаар төсөвлөжээ. Үүний хамтад хүнийг үй олноор устгах бусад төрлийн зэвсэг, тухайлбал мэдрэлийн эрхтнийг хордуулах бинарын хорт химийн зэвсэг үйлдвэрлэхэд 155 сая доллар зориулахаар шийдвэрлэжээ.

Энэ бүхэн нь тэдний хэлж байгаагаар гадны аюулаас батлан хамгаалах зорилготой юм уу? гэвэл огт тийм биш. Тийм шаардлага АНУ-д огтхон ч алга. Үүний давын өмнөх зорилт нь зэр зэвсгээр давуутай болж ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг өрнө, дорно, хойд, өмнөдөөс бүслэхэд оршиж байгаа нь хэн бүхэнд илэрхий боллоо.

Жишээ нь, Японыг Америкийн «цөмийн авианосец» болгохыг эрмэлзэгч Вашингтоны эрх баригчид энэ орны Йокосука, Сасебо зэрэг портыг АНУ-ын тэнгисийн цэргийн хүчний түшиц буудал болгон, эхний цохилт хийх үүрэг бүхий «Мидуэй» хэмээх авианосецийг байрлуулж байгаа нь тус улсын энхийг эрхэмлэгч олон нийтийн сэтгэлийг ихэд шаналгааж байна. Энэ нь цөмийн зэвсгийг гаднаас нэвтрүүлэхгүй, хэрэглэхгүй, үйлдвэрлэхгүй гэж хуульчлан тунхагласан хүндтэй зарчмаас ухарч улс орноо цэрэгжүүлэх замд орж буй Японы түрэмгий хэсгийг илт зоригжуулж байна.

Энэ бүх цэрэг зэвсгийн зорилго юунд оршиж түүний хурц үзүүр хэн рүү, юу руу чиглэж байна вэ? гэвэл дэлхийн социализм, хувьсгалт болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг бүсэлж, хэрэв нөхцөл бүрдвэл тэдний эсрэг «загалмайтны аян дайн» хийж, дэлхий дахины хүчний харьцааг империализмд ашигтайгаар өөрчлөхөд оршиж байна. Үүнийг империалист орны хэвлэл мэдээллийн хэрэгсэл батлаад зогсохгүй, империалист гүрнүүдийн албаны зарим төлөөлөгчид ч нуухгүй байна. Тэгвэл энэ бүх аюулыг хэн эрхлэн эсэргүүцэж, империалист колончлогчдын эзлэн боолчлох санаархлыг хазаарлан таслахын төлөө хэн тууштай тэмцэж байна вэ? гэдэг асуулт гарч ирэх юм. Тэр тэмцлийг Зөвлөлт Холбоот Улс, социалист хамтын нөхөрлөлийн орнууд л гуйвалтгүй манлайлсаар байгааг дэлхийн дэвшилт олон нийт чин сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч байна.

Ийм учраас дайн ба энхийн асуудалд хэрхэн яаж хандах нь одоо үед бүх орны удирдах зүтгэлтэн улс төрийн бүх нам, байгууллагын байр суурийг тодорхойлох хамгийн хурц тод шалгуур болж байна.

Нөгөө талаар энэ нь бүх нийтийн энх тайвныг хамгаалан бэхжүүлэх талаар тухайн улс орны хүлээсэн үүргийг гүнзгий ухамсарлаж, үндэстний болон бүх нийтийн эрх ашгийг зөв хослуулахын чухлыг улс төрийн зүтгэлтэн бүрээс шаардаж байна.

Үүнд хүн ам, дэвсгэр нутгийн тоо хэмжээ, цэрэг—эдийн засгийн потенциалараа тив районы төдийгүй дэлхий дахины улс төрийн амьдралд томоохон үүрэг гүйцэтгэх ёстой БНХАУ-ын эрх баригчдын дээрх асуудлаар баримталж буй байр суурь олны анхаарлыг арга буюу татаж байна.

Олон жилийн турш империалист колончлол, милитарист булаан эзлэгчдийн дарангуйллын хүнд бэрх зовлонг амсаж маоист «соёлын хувьсгал» мэт улс төрийн адал балмад кампанийн хөнөөлт хор уршгаас одоо болтол ангижирч чадаагүй байгаа Хятад шиг оронд тайван нөхцөл, энхийн байгуулалт юу юунаас чухал баймаар. Гэтэл хэрэг дээрээ тийм биш нь тун ч харамсалтай.

Хүчирхийлэл, зэвсэгт өдөөн хатгалга, ужиг урт дайн дажныг хувьсгалын цорын ганц арга гэж онголон тахиж эрхэмлэн үзэж байсан «соёлын хувьсгал» гэгчийн гунигт үеийг эс тооцлоо гэхэд Бээжингийнхэн энхийн байр сууринд баттай зогсох байтугай дайны эх сурвалжийн тухай асуудалд ангич бишээр хандсан хэвээр байгаа нь харамсалтай. Түүгээр үл барам тэд дайны эсрэг олон улсын улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх тэмцлийг манлайлж яваа ЗХУ-ыг одоогийн түгшүүртэй байдлын гол нэг эх сурвалж гэж хортойгоор гүтгэж, түүнийг АНУ-тай нэг байранд адилтган тавьсаар байна.

Бээжингийнхэн аман дээрээ энх тайвны төлөө ялангуяа гурав дахь ертөнцийн улс түмний эрх чөлөөг хүндэтгэнэ гэж зарладаг атлаа хүн төрлөхтнийг халуун цөмийн сүйрэлд түлхэн оруулах бодлого илэрхий баримталж байгаа Рейганы засаг захиргаатай энх тайван, социализмын хүчийг хамтран эсэргүүцэх үндсэн дээр сүлбэлдэж, улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг үнэн чанартаа империалистуудтай хамтран тэмцэж байгааг юу гэж ойлгох вэ? Үүнийг энхийг эрхэмлэгчдийн эгнээнээс урван тэрсэлсэн хэрэг гэж үнэлэхээс өөр аргагүй юм. Хятадын эрх баригчид империализмаас холдож болгоомжлох дүр үзүүлж бас социалист хамтын нөхөрлөлийн нэлээд оронтой харилцааг хэвийн болгож идэвхжүүлэх хандлага гаргаж байгаа хэдий боловч АНУ Хятадыг «найрсаг орны» тоонд оруулж, Зөвлөлтийг хамтран эсэргүүцэх ажлаа Бээжинтэй нягт уялдуулснаараа сайрхан байгааг хүмүүс анхаарахгүй байж чадахгүй юм. Энэ нь ямар ч л гэсэн Хятадын эрх баригчид «найрсаг орон» гэгдэх үндэслэлийг АНУ-ын удирдагчдад өгч чадсаныг баталж байгаа хэрэг.

Цөмийн зэвсгийн хүчээр дэлхий дахинд ноёрхлоо тогтоох гэж империалист түрэмгий хүч улайран тэмүүлж байгаа одоогийн нөхцөлд тэрхүү харгис хүчийг зулгуйдах замаар ашиг завшаан олж, цөмийн дайны аюулаас мултарч үлдэнэ гэж бодвол тэр нь шиг тэнэг зүйл байхгүй билээ.

Империалистүүд зэвсгийнхээ үзүүр, пуужингийнхаа овоо харааг юуны өмнө социалист орнууд руу, ерөөсөө дэлхийн социализм руу онилж байгаа болохоор БНХАУ түүний гадна үлдэхгүй гэдгийг ойлгох цаг нэгэнт болжээ.

Энэ нь хятадын ард түмний жинхэнэ дайсан, хань хоёрыг ялган таньж, тэдэнтэй харилцах бодлогоо зөв сонгож авахын чухлыг онцлон зааж байна. Бусад улс түмэнтэй, юуны өмнө өөрсдийн анги, зорилго нэгт анд холбоотонтойгоо нягт нөхөрлөж, хамтран ажиллах замаар амгалан—тайван нөхцөлд хөгжил дэвшлийн замаар урагшлан өөдлө-

хийг гүнээ сонирхогч хятадын хөдөлмөрч ард түмэнд их гүрний аминч явцуу ашиг сонирхол ямар ч ач тус болохгүйг өнгөрсөн түүх тодорхой харууллаа.

Ийм учраас давын түрүүнд айл хөрш орнуудтайгаа сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг сэргээхийг Хятадын нийгмийн хөгжлийн бодит хэрэгцээ шаардаж байна. Ялангуяа Хятад, Зөвлөлтийн харилцааг хэвийн болгох явдал зөвхөн хоёр орны төдийгүй Ази болон даян дэлхийд энх тайван тогтвортой байдлыг хангах, империалист хүчний түрэмгий санаархлыг хазаарлах эрх ашигт нийцнэ гэж дэлхийн дэвшилт олон нийт үзэж байгааг Монголын олон нийт нэгэн адил хуваалцаж байна. Гэтэл Хятадын удирдагчдын доторхи их гүрний дээрэнгүй үзэлт бүлгийнхэн БНХАУ-ын эрх чөлөө, тусгаар тогтнолыг хөнөөх аюул империализмийн талаас биш зөвхөн ЗХУ-ын зүгээс гарч байгаа мэтээр дүрслэж тийм хортой буруу үзэл санаагаар ард түмнээ төөрөгдүүлж байгааг тэмдэглэхгүй байж болохгүй юм. Дайны аюулыг сэргэмжлэн зайлуулах асуудлаар Бээжин үнэн чанартаа АНУ-ын удирдлагатай ижил буюу өрнөдийнхний зэвсгийг нэмэгдүүлж харин Зөвлөлтийн зэвсгийг дангаар хурааж устгахад чиглэсэн бодлого баримталж байна.

Империализмийг болон дайныг эсэргүүцэх тэмцлийн амжилт нь уг тэмцэлд оролцогчдын эв нэгдэл хийгээд тэдний оруулж буй бодит хувь нэмрээс шууд шалтгаалах учраас Бээжингийн баримталж буй одоогийн байр суурь нь нийтийн тэмцэлд тус болох байтугай ихээхэн хэмжээгээр хор хүргэж байна.

Зөвлөлт Холбоот Улсын зэвсэгт хүч нь империалист хүчнийг хориглон барих гол хүчний үүргийг гүйцэтгэхдээ зөвхөн ганц биеийн ашгийг биш, бүх нийтийг, түүний дотор БНХАУ-ыг өмгөөлөн хамгаалах бамбай болж байгааг үгүйсгэж хэрхэвч болохгүй юм. Чухамхүү энэ нь үндэсний болон бүх нийтийн эрх ашгийг зөв хослуулахын хурц тод жишээ болж байна. Шинэ тулгар Хятад ард улсын хувьсгалт ололтод империалистууд шууд заналхийлж агсан 50-аад оны үед БНХАУ-ыг чухамхүү ЗХУ халхлан хамгаалж байсныг сайн мэдэх хүмүүс Хятадад одоо ч цөөнгүй байх ёстой. Энэ хүмүүс нь Хятадын ард түмнийг хүнд хэцүү үед Рейган, Полпот—Иенг Сари, Нордом Сианук мэтийн зандалчид биш, анги, зорилго нэгт Зөвлөлт, Монгол, Вьетнам, Герман, Унгар нөхөд талархан дэмжиж байсныг бүр ч сайн мэдэж байгаа нь дамжиггүй.

Чухамхүү санаа зорилго нэгтний нэгдэл нягтрал, бат зузаан хамтын ажиллагаа нь энх тайван, социализмын аливаа дайсны түрэлтийг амжилттай няцаах хүчирхэг хүчин зүйл болсоор ирснийг амьдрал баталж байна.

Энэ хүчин зүйлийг хүлээн зөвшөөрөх явдал цөмийн дайны аюулыг эсэргүүцэх, дэлхий дахинд түүний дотроо Азид энх тайван, тогтвортой байдлыг хангах тэмцэлд шийдвэрлэх ач холбогдолтой болж байна.

Хүйс тэмтрэн устгах цөмийн дайны аюул бүх орныг, түүний дотор БНХАУ-ыг нэг адил заналхийлж буй одоогийн энэ маш хариуцлагатай бөгөөд эмзэгтэй үед дайн ба энхийн асуудлаар баримталж буй бодлогодоо хятадын удирдагчид зохих дүгнэлт хийнэ байх гэдэгт Монголын олон нийт найдаж байна.

НАЦИОНАЛЬНЫЕ И ВСЕОБЩИЕ ИНТЕРЕСЫ

(Р е з ю м е)

Через 39 лет после окончания Второй мировой войны мир стоит на грани новой, еще более ужасной катастрофы, которая приведет к гибели человечества. Несмотря на это, ослепленная ненавистью к социализму реакционная верхушка империализма продолжает преступную политику взвинчивания международной напряженности. Стремясь к безудержному наращиванию военных потенциалов, развертыванию новых видов вооружений, совершенствованию более устрашающих типов оружия, американский империализм наивно надеется уничтожить мировой социализм, подавить революционное сопротивление народов, установить свое господство над всем миром. На территории примерно 30 стран размещены более 1500 военных баз и объектов США, отдаленные страны и районы объявлены зонами американских «жизненных интересов».

Не прекращается увеличение военного присутствия США в Азии и на Тихом океане. В авантюрных планах Вашингтона важное место отводится азиатским «партнерам», в первую очередь Японии, правящая верхушка которой усиленно возрождает в стране милитаризм и желает превратиться в «непотопляемый авианосец», Эти акции американского империализма вызваны стремлением добиться военного превосходства над СССР и окружить военным кольцом страны социалистического содружества.

В современной, как никогда обострившейся, обстановке отношение к вопросам войны и мира партийных и государственных деятелей разных стран является основным критерием их политической деятельности. Именно поэтому народы мира вправе расценивать внешнюю политику «равной отдаленности» и «дифференцированного подхода» нынешнего китайского руководства как идущую вразрез с национальными интересами китайского народа и общими интересами человечества.

Успех борьбы против империализма, за устранение опасности войны во многом зависит от единства и реального вклада ее участников. Нынешняя позиция китайских лидеров отнюдь не направлена на поддержку этой общей борьбы, а создает значительные препятствия. Между тем, такая крупная держава как Китай могла бы внести крупный позитивный вклад в дело мира и социализма.

Советский Союз, играющий главную роль в противостоянии империалистической реакции и обеспечении всеобщего мира, преследует не только узконациональные, но и общечеловеческие интересы. Единство и сплоченность, тесное сотрудничество были и остаются влиятельным фактором успешной борьбы с врагами мира и социализма. Признание этого фактора имеет решающее значение в противоборстве ядерной войне, упрочению мира и стабильности в Азии и во всем мире.